



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/71

Өмнөдэлгэр сум

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,  
техникийн урьдчилсан үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 7.1.2, 7.13, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/12 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын урьдчилсан үзлэгийг 2026 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Оюунгэрэл	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баярхүү	Татварын улсын байцаагч
Гишүүд:	Д.Жамъяндорж	Хэсгийн төлөөлөгч
	Д.Наранчимэг	Наран багийн Засаг дарга
	Г.Эрдэнэсүвд	Баянзүрх багийн Засаг дарга
	А.Баянмөнх	Хэнтий багийн Засаг дарга
	М.Сод-Ирээдүй	Талын булаг багийн Засаг дарга
	Э.Заяабаяр	Чандган багийн Засаг дарга
	С.Шижирбаатар	Төвийн багийн Засаг дарга

3. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулах, техникийн үзлэгийн өмнө авто тээврийн хэрэгслийн албан татварыг

хураан авах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нар болон татварын улсын байцаагч (Д.Баярхүү)-д, хуваарьт өдрүүдэд хэв журам сахиулахыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч (Д.Жамъяндорж)-д тус тус даалгасугай.

4. Авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг оношлогоонд ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглон, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч (Д.Жамъяндорж)-д даалгасугай.

5. Тээврийн хэрэгслийн улсын үзлэгийг хугацаанд нь чанартай явуулан дүнг нэгтгэж танилцуулахыг комиссын дарга (Б.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

